

ГАЗРЫГ УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНД АВАХ, ГАРГАХ, ТҮҮНИЙ ХЭМЖЭЭ, ЗААГИЙГ ТОГТООХ, АШИГЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь Газрын тухай хуулийн 16.1-д заасан зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, улсын тусгай хэрэгцээнээс гаргах болон улсын тусгай хэрэгцээний газрыг ашиглахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2.Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, тусгай хэрэгцээнээс гаргах (цаашид “газрыг тусгай хэрэгцээнд авах, гаргах” гэх) үйл ажиллагаанд энэ журам болон холбогдох бусад хууль, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм, журмыг дагаж мөрдөнө.

Хоёр.Улсын тусгай хэрэгцээнд авах газарт тавигдах ерөнхий шаардлага

2.1.Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тохиолдолд дор дурдсан ерөнхий шаардлагыг хангасан байна:

2.1.1.Улс, бүс нутгийн хэмжээний хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан байх;

2.1.2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байх;

2.1.3.Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар нь тухайн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар гарсан эрх бүхий этгээдийн шийдвэртэй байх;

2.1.4.Улсын болон Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийцсэн байх;

2.1.5.Тусгай хэрэгцээнд авах газрын байршил, хэмжээг хууль тогтоомж, норм, дүрэм, стандартад үндэслэн тогтоосон байх.

2.2.Улсын тусгай хэрэгцээнд авах газрын хил заагийг тогтоохдоо иргэн, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшил, ашиглалтын газар болон газрын тос, уламжлалт бус газрын тос, ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай аль болох давхцуулахгүй байх зарчмыг баримтлана.

Гурав.Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах үйл ажиллагаа

3.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга эсхүл холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага газрыг улсын тусгай хэрэгцээнд авах талаар газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүсэлт гаргана.

3.2.Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах хүсэлт (цаашид “Хүсэлт” гэх)-эд дараах баримт бичгийг хавсарган ирүүлнэ:

3.2.1.Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах үндэслэл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон танилцуулга;

3.2.2.Газрын байршил, хил заагийн эргэлтийн цэгүүдийн геодезийн солбицол, талбайн хэмжээг тодорхойлсон зураг, мэдээлэл;

3.2.3.Газрын тухай хуулийн 16.1.9, 16.1.10, 16.1.12-16.1.14, 16.1.17-16.1.19-д заасан зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авах газарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник эдийн засгийн үндэслэл, хил заагийг тогтоож холбогдох эрх бүхий этгээдээр баталгаажуулсан зураг төсөл, төлөвлөгөө, тооцоо судалгааны баримт бичиг;

3.2.4.Газрын тухай хуулийн 16.1.16-д заасан зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авах газарт паркийн хөгжлийн төлөвлөгөө;

3.2.5.Нууцын зэрэглэлтэй улсын тусгай хэрэгцээнд авах газарт нууцын зэрэглэлийг тогтоосон эрх бүхий байгууллагын албан бичиг.

3.3.Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүсэлтийг судлан энэ журам болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэн шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллага, албан тушаалтнаас бүрдсэн ажлын хэсэг байгуулан ажиллаж болно.

3.4.Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүсэлтийг хүлээн авсны дараа дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.4.1.Агаар, сансрын болон зохих масштабын байр зүйн зургийн мэдээллийг ашиглаж улсын тусгай хэрэгцээнд авахаар төлөвлөж буй газар нь бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтын газар, газрын тос, уламжлалт бус газрын тос, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбайтай давхцаж байгаа эсэх, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хотын хөгжлийн төлөвлөгөөний баримт бичигт нийцэж байгаа эсэхийг шалгах;

3.4.2.Тусгай хэрэгцээнд авах газрын нөлөөлөлд өртөж буй иргэн, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшилд байгаа газрын нөхөх олговрын урьдчилсан тооцоо, судалгааг хийх;

3.4.3.Тусгай хэрэгцээнд авах газрын нөлөөлөлд өртөж буй иргэн, хуулийн этгээдэд олгох нөхөх олговорт шаардагдах зардлыг хэрхэн шийдвэрлэх талаар энэ журмын 3.1-д заасны дагуу хүсэлт гаргасан байгууллагаас тодруулга авах;

3.4.4.Холбогдох аймаг, нийслэлийн Засаг даргаас газрыг улсын тусгай хэрэгцээнд авахтай холбогдуулан санал авах, аймаг, нийслэлийн газрын албанаас газар ашиглалтын дэлгэрэнгүй судалгаа гаргуулах.

3.4.5. Энэ журмын 3.1.-д заасан хүсэлт гаргасан байгууллагын саналыг үндэслэн улсын тусгай хэрэгцээнд авахаар төлөвлөж буй газрын хил заагт Эрх бүхий байгууллагын шийдвэр гарч баталгаажих хугацаанд шинээр газар олгох үйл ажиллагааг Газрын кадастрын мэдээллийн санд хаалт хийж, зогсоож болно.

3.5.Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн газрыг улсын тусгай хэрэгцээнд авах үндэслэл бүрдээгүй, эсхүл энэ журмын 3.2-т заасан бүрдлийг хангаагүй тохиолдолд тодорхой үндэслэл, тайлбарыг гарган хүсэлтийг буцаана.

3.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ журмын 3.4.4-т заасан саналыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулна.

3.7. Аймаг, нийслэлийн газрын алба улсын тусгай хэрэгцээнд авах газрын байршилд агаар, сансрын зураг ашиглан суурин болон хээрийн хэмжилт тодруулалтыг хийж газар ашиглалтын судалгааг гарган дараах мэдээллийг бэлтгэнэ:

3.7.1. Эрх зүйн харилцаа үүссэн болон үүсээгүй нэгж талбаруудын газар ашиглалт, үл хөдлөх эд хөрөнгө, хашаа, байшин, объектын судалгаа;

3.7.2. Орон нутгийн тусгай хэрэгцээ, түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн судалгаа.

3.8. Аймаг, нийслэлийн газрын алба энэ журмын 3.4.4-т заасан саналыг хүлээн авснаас хойш 20 хоногийн дотор тусгай хэрэгцээнд авах газрын нөлөөлөлд өртөж буй газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээдэд Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлд заасны дагуу сонсох ажиллагааг газрыг улсын тусгай хэрэгцээнд авах хүсэлт гаргасан байгууллагатай хамтран зохион байгуулж тайлан, холбогдох баримтыг Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

3.9. Аймаг, нийслэлийн Засаг дарга газрыг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн холбогдох саналаа 30 хоногийн дотор ирүүлээгүй тохиолдолд дэмжсэн санал өгсөнд тооцно.

3.10. Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 3.4, 3.6, 3.7-д заасан арга хэмжээг хэрэгжүүлж, холбогдох тооцоо судалгаа, баримт материалыг бүрдүүлсний дараа тэдгээрт үндэслэж газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай дүгнэлтийг боловсруулна.

3.11. Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 3.10-т заасан дүгнэлтийг дараах баримт бичгүүдийн хамт Засгийн газарт хүргүүлэн шийдвэрлүүлнэ:

3.11.1. Улсын тусгай хэрэгцээнд авах газрын байршил, талбайн хэмжээ, хил заагийн эргэлтийн цэгийн солбицол бүхий шийдвэрийн төсөл, танилцуулга;

3.11.2. Газрын байршлыг дүрсэлсэн зохих масштабын зураг;

3.11.3. Тухайн газар нутгийг харьяалах аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол;

3.11.4. Нөлөөлөлд өртөж буй иргэн, хуулийн этгээдэд Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу сонсох ажиллагааг зохион байгуулсан тухай тайлан, баримт бичиг, нөхөх олговрын тооцоо, судалгаа;

3.11.5. Газрыг улсын тусгай хэрэгцээнд авсны дараа тухайн газрыг ашиглах горим, дэглэм.

3.12. Энэ журамд заасан шийдвэрийн төсөлд тусгай хэрэгцээний газрыг хариуцах болон шаардлагатай нөхөх олговрыг шийдвэрлэх байгууллага, албан тушаалтныг тодорхой тусгана.

3.13. Газрын тухай хуулийн 16.1.1-д заасан зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тохиолдолд газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 3.10-д заасан дүгнэлтийг холбогдох бусад баримтын хамт Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.14. Газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсны дараа доорх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.14.1.Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага улсын тусгай хэрэгцээнд авсан газрын нэгж талбарын эргэлтийн цэгийг батлагдсан солбицлоор газарт бэхлэх, кадастрын зураг үйлдэн газрын кадастрын мэдээллийн санд бүртгэнэ;

3.14.2.Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 3.14.1-д заасан газрын кадастрын мэдээллийн сангийн холбогдох мэдээллийг байгаль орчны болон ашигт малтмалын асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ;

3.14.3.Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, нөгөө талаас холбогдох төрийн захиргааны төв эсхүл төрийн захиргааны байгууллага “Улсын тусгай хэрэгцээний газрын ашиглалтыг хариуцах” тухай гэрээ байгуулна.

3.14.4.Улсын тусгай хэрэгцээний газарт газар ашиглалтын олон төрөл, зориулалт үүсэх нөхцөлд Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийг үндэслэн хэрэгжүүлэх хугацаа, газар ашиглалтын зориулалт, хэмжээ, байршлыг нэгж талбар бүрээр тогтоосон газар ашиглалтын төлөвлөгөөтэй байна. Газар ашиглалтын төлөвлөгөөг газар зохион байгуулалт, хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийн тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

3.14.5.Энэ журмын 3.14.4.-д заасан төлөвлөгөө нь газар зохион байгуулалт, хот байгуулалтын хууль журам, норм стандарт, аргачлалд нийцсэн байх.

3.14.6.Энэ журмын 3.14.4-д заасан газар ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах ажлыг Улсын тусгай хэрэгцээний газрын ашиглалтыг хариуцсан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулж, холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга, Хотын захирагчтай хамтран батална.

3.14.7.Энэ журмын 3.14.4-д заасан арга хэмжээг хэрэгжүүлсний дараа нөлөөлөлд өртөж байгаа иргэн, хуулийн этгээдэд нөхөх олговор олгох, тухайн газрыг чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажлыг холбогдох Засаг дарга, аймаг, нийслэлийн Газрын алба, тусгай хэрэгцээний газрын ашиглалтыг хариуцсан байгууллагатай хамтран зохион байгуулна.

3.15.Энэ журмын 3.14.3-т заасан гэрээнд улсын тусгай хэрэгцээнд авсан тухайн газрыг төлөвлөх, ашиглах, хамгаалах, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгэх болон хяналт тавих, түүнд мөрдөгдөх дэглэм, горим, нөлөөлөлд өртөж буй иргэн, хуулийн этгээдийн газар, ашигт малтмал, газрын тосны тусгай зөвшөөрөлтэй талбайн асуудлыг шийдвэрлэх талаар талуудын эрх үүргийг тусгана.

3.16. Улсын тусгай хэрэгцээний газрын ашиглалтыг хариуцсан төрийн захиргааны төв эсхүл төрийн захиргааны байгууллага нь газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарснаас хойш 1 жилийн дотор энэ журмын 3.14.-т заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Дөрөв.Улсын тусгай хэрэгцээний газрыг нөхөх олговортойгоор чөлөөлөх

4.1.Улсын тусгай хэрэгцээний газрын нөлөөлөлд өртөж буй иргэн, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшлийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн солих буюу

эргүүлэн авах тохиолдолд Газрын тухай хуулийн 18.1.3-д заасны дагуу нөхөх олговор олгоно.

4.2.Аймаг, нийслэлийн Газрын алба газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн улсын тусгай хэрэгцээний нөлөөлөлд өртөж буй иргэн, хуулийн этгээдэд газар чөлөөлөх тухай мэдэгдэл хүргүүлж, газар чөлөөлөх арга хэмжээг энэ журмын 3.14.4-д заасан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.

4.3.Улсын тусгай хэрэгцээний газрын нөлөөлөлд өртөж буй иргэн, хуулийн этгээдийн газар нь тухайн тусгай хэрэгцээний газарт хэрэгжих газар зохион байгуулалт, хот байгуулалтын төлөвлөгөө болон зураг төсөлтэй нийцэж байвал газар эзэмших эрхийн гэрчилгээний хүчинтэй хугацаанд газрыг ашиглуулах, цаашид газар ашиглуулах эрх олгох асуудлыг тусгай хэрэгцээний газрын ашиглалтыг хариуцсан байгууллага, төсөл хэрэгжүүлэгчийн саналын дагуу хуульд заасан эрх бүхий этгээд шийдвэрлэнэ.

4.3.1. Улсын тусгай хэрэгцээний газрын нөлөөлөлд өртөж буй иргэн, хуулийн этгээдийн газрын эрхийг шилжүүлэх тохиолдолд эрхийн гэрчилгээний хугацааг сунгахгүйгээр үлдсэн хугацааг тооцож эрхийн гэрчилгээг шилжүүлэх

4.4.Иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тохиолдолд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 37.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

4.5.Энэ журмын 4.2-д заасан мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш тухайн газарт барьж байгуулсан барилга байгууламж, үл хөдлөх эд хөрөнгийн үнийг нөхөх олговор тооцохгүй.

4.6.Улсын тусгай хэрэгцээнд авах газар газрын тос, уламжлалт бус газрын тос, ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан тохиолдолд нөхөх олговор олгох асуудлыг Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран холбогдох хууль, журамд заасны дагуу шийдвэрлэх бөгөөд ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбайг чөлөөлөх асуудал нь энэ журамд хамаарахгүй.

4.7.Нөлөөлөлд өртөж буй иргэн, хуулийн этгээдтэй нөхөх олговрын талаар урьдчилан тохиролцохдоо талууд нөхөх олговрын хэлбэр, үнэлгээ болон бусад холбогдох асуудлаар харилцан тохиролцсон байна.

4.8.Аймаг, нийслэлийн Газрын алба газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртөж буй иргэн, хуулийн этгээдийн газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7.2.4-д заасан газар, үл хөдлөх эд хөрөнгийн нөхөх олговрын зориулалттай үнэлгээний аргачлалын дагуу үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй этгээдээр хийлгэнэ.

4.9.Нөхөх олговрын зориулалттай хөрөнгийн үнэлгээнд доорх зүйл хамаарна:

4.9.1.газар;

4.9.2.үл хөдлөх эд хөрөнгө;

4.10.Нөлөөлөлд өртөгчөөс хөрөнгийн үнэлгээ хийхэд шаардлагатай баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 5 (тав) хоногийн дотор энэ журмын 4.8-д заасан хуулийн этгээдэд хүргүүлнэ.

4.11. Аймаг, нийслэлийн Газрын алба энэ журмын 4.8-д заасан хуулийн этгээдээс ирүүлсэн хөрөнгийн үнэлгээний тайланг хүлээн авснаас хойш ажлын 3 (гурав) хоногийн дотор нөлөөлөлд өртөгч иргэн, хуулийн этгээдэд тайлантай танилцах талаар мэдэгдэнэ.

4.12. Нөлөөлөлд өртөгч иргэн, хуулийн этгээд хөрөнгийн үнэлгээний тайлантай танилцаж, зөвшөөрөх, эсхүл өөрийн зардлаар хөрөнгийн үнэлгээг дахин хийлгэх талаар бичгээр мэдэгдэж, албан хаагч уулзалт бүрд тэмдэглэл үйлдэн баталгаажуулж, хувийн хэрэгт хадгална.

4.13. Нөлөөлөлд өртөгч иргэн, хуулийн этгээд нь өөрийн зардлаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэх тохиолдолд энэ журмын 4.8-д заасны дагуу хөрөнгийн үнэлгээг хийлгэж, үнэлгээний тайлангийн эх хувийг аймаг, нийслэлийн Газрын албанд хуанлийн 14 (арван дөрөв) хоногт багтаан хүргүүлнэ.

4.14. Аймаг, нийслэлийн Газрын алба энэ журмын 4.10-т заасан хугацаанд хүргүүлсэн тайланг хүлээн авч, энэ журмын 4.13-т заасан үнэлгээнээс зөрүүтэй байвал Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 22.1-д заасан хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагад хандаж ажлын 3 (гурав) хоногийн дотор хүргүүлнэ.

4.15. Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг эцсийн үнэлгээнд тооцно.

4.16. Энэ журмын 4.15-д заасан дүгнэлтийг нөлөөлөлд өртөгчид ажлын 3 (гурав) хоногийн дотор мэдэгдэнэ.

4.17. Хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй этгээд, хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага өөрийн гаргасан тайлан, дүгнэлтийн үнэн зөв байдлыг бүрэн хариуцах бөгөөд эдгээртэй холбогдон гарах аливаа эрсдэлийг Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасны дагуу үнэлгээ гаргасан этгээд хариуцна.

4.18. Аймаг, нийслэлийн Газрын алба газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртөж буй иргэн, хуулийн этгээдийн газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээний тайланг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

4.19. Хөрөнгийн үнэлгээний асуудлаар хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагад хандахтай холбогдон гарах зардлыг тусгай хэрэгцээний газрын ашиглалтыг хариуцсан байгууллага, төсөл хэрэгжүүлэгч хариуцна.

4.20. Нөлөөлөлд өртөж буй иргэн, хуулийн этгээдэд олгох нөхөх олговорт шаардагдах хөрөнгийг төсөл хэрэгжүүлэх аж ахуйн, нэгж байгууллага болон гадаадын зээл, тусламжаас олгож болох бөгөөд газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг даргын мэдэлд шилжүүлнэ.

4.21. Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 4.18.-д заасан хөрөнгийн үнэлгээний тайланг үндэслэн нөхөх олговорт шаардагдах зардлыг тооцож тусгай хэрэгцээний газрын ашиглалтыг хариуцсан байгууллага, төсөл хэрэгжүүлэгчид хүргүүлнэ.

4.22. Тусгай хэрэгцээний газрын ашиглалтыг хариуцсан байгууллага, төсөл хэрэгжүүлэгч энэ журмын 4.21.-д заасан нөхөх олговорт шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах саналаа санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

4.23. Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нөхөх олговорт шаардагдах хөрөнгийн үнэлгээ, тооцоо судалгааг санхүүгийн асуудал

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газрын ажлын албанд хүргүүлнэ.

4.24.Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 4.19-д заасан хөрөнгийг газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг даргын мэдэлд шилжүүлнэ.

4.25.Энэ журмын 3.14.3-д заасан гэрээнд болон хуульд өөрөөр заагаагүй бол нөхөх олговрыг бүрэн төлж дуусгасан өдрөөс хойш 30 хоногийн дотор нөлөөлөлд өртөж буй иргэн, хуулийн этгээд уг газрыг бүрэн чөлөөлж, тухайн газар нутгийг хариуцсан Засаг даргын мэдэлд шилжүүлнэ.

4.26.Нөлөөлөлд өртөж буй иргэн, хуулийн этгээдэд энэхүү журамд заасан хугацаанд газраа чөлөөлөөгүй тохиолдолд Газрын тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасны дагуу газар албадан чөлөөлөх арга хэмжээг авна.

4.27.Нөлөөлөлд өртөгчид олгох нөхөх олговрыг хөрөнгийн үнэлгээтэй нь дүйцүүлэн дараах боломжит хэлбэрээр олгоно:

4.27.1.газрыг тусгай хэрэгцээний газрын гадна байрших газраар дүйцүүлэн олгох;

4.27.2.газрыг нөхөх олговрын мөнгөн хэлбэрээр худалдан авах;

4.27.3.хуульд заасан бусад.

4.28.Нөхөх олговрыг газраар дүйцүүлэн олгох тохиолдолд газрын төлөв байдал, чанарыг дордуулахгүй байх.

4.29.Нөлөөлөлд өртөгчийн хөрөнгийн үнэлгээг үндэслэн нөхөх олговрын хэлбэрийг харилцан тохиролцож, тэмдэглэл үйлдэнэ.

4.30.Энэ журмын 4.29-д заасан тэмдэглэл болон бусад холбогдох баримт бичгийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга нөхөх олговор олгох шийдвэрийг гаргана.

4.31.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Хотын захирагч нөлөөлөлд өртөж буй иргэн, хуулийн этгээдтэй урьдчилан тохиролцсоны дагуу газрыг нөхөх олговортойгоор эргүүлэн авах, эсхүл газрыг дүйцүүлэн олгох тухай шийдвэр гарган тухайн газрын өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг дуусгавар болгоно.

Тав.Улсын тусгай хэрэгцээний газрыг ашиглах, хамгаалах

5.1.Улсын тусгай хэрэгцээний газрыг ашиглахад дараах нийтлэг горим, дэглэмийг дагаж мөрдөнө:

5.1.1.Улсын тусгай хэрэгцээнд авсан газрыг зориулалтын дагуу ашиглаж, ашиглуулах;

5.1.2.Тухайн газраас зориулалтын бусаар иргэн, хуулийн этгээдэд өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулахгүй байх;

5.1.3.Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг холбогдох хууль журамд заасан хугацаанд мэргэжлийн байгууллагаар хийлгэж байх;

5.1.4.Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хууль тогтоомж, энэ журмын 3.14.3-д заасан гэрээнд заасны дагуу хэрэгжүүлэх;

5.1.5.Улсын тусгай хэрэгцээнд авсан газрын зориулалтыг өөрчлөх, хуулиар зөвшөөрөөгүй үйл ажиллагаа явуулахыг хориглох.

5.2.Иргэн, хуулийн этгээд улсын тусгай хэрэгцээний газарт газар ашиглах хүсэлтээ улсын тусгай хэрэгцээний газрын ашиглалтыг хариуцсан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад гаргана.

5.3.Улсын тусгай хэрэгцээний газрын ашиглалтыг хариуцсан төрийн захиргааны төв эсхүл төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 5.2.-т заасан хүсэлтийг хүлээн авч улсын тусгай хэрэгцээний газрын Газар ашиглалтын төлөвлөгөө, Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, зураг төсөлд нийцэж байгаа эсэхийг шалгана.

5.4.Улсын тусгай хэрэгцээний газрын ашиглалтыг хариуцсан төрийн захиргааны төв эсхүл төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 3.14.4-т заасан төлөвлөгөө, зураг төслийг үндэслэн иргэн, хуулийн этгээдэд газар ашиглуулах саналаа холбогдох Засаг дарга, Хотын захирагчид гаргана.

5.5.Улсын тусгай хэрэгцээний газрын ашиглалтыг хариуцсан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага нь улсын тусгай хэрэгцээний газрын газар ашиглалтын төлөвлөгөө, Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, зураг төсөлд нийцүүлэн нөлөөлөлд өртөж буй иргэн, хуулийн этгээдийн газрыг шилжүүлэх, чөлөөлөх тухай саналаа холбогдох Засаг даргад гаргана.

5.6. Энэ журмын 5.5.-д заасан саналыг үндэслэн холбогдох Засаг дарга, Хотын Захирагч дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.6.1.Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх;

5.6.2.Газрын тухай хуульд заасны дагуу тухайн жилд эзэмшүүлэх, ашиглуулах Засгийн газрын жагсаалтад тусгах

5.7.Засгийн газрын тогтоолоор батлагдсан жагсаалт, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолыг үндэслэн холбогдох Засаг дарга, Хотын Захирагч дараах хууль журмын дагуу газар ашиглуулах шийдвэр гаргана.

5.7.1.Төсвийн байгууллага, төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн дагуу түншлэл хэрэгжүүлэгч, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хэрэгжүүлэгчид хүсэлтээр;

5.7.2.Энэ журмын 5.7.1.-д зааснаас бусад тохиолдолд Засгийн газраас баталсан дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулах журмын дагуу шийдвэрлэнэ.

5.8.Холбогдох Засаг дарга, Хотын захирагч энэ журмын 5.7-д заасны дагуу шийдвэр гаргасан тохиолдолд газар ашиглуулах гэрээ байгуулж, гэрээнд газрын төлбөр, ашиглах хугацааг тодорхой тусгана.

5.9.Газрын тухай хуулийн 16.1.2-д заасан зориулалтаар газар ашиглуулах тохиолдолд дор дурдсан нөхцөлөөр ашиглуулна:

5.9.1.Улсын хилийн зурваст газар ашиглуулах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр гарсны дараа “Улсын хилийн зурваст газар ашиглах гэрээ”-г холбогдох талууд байгуулна.

5.9.2.Улсын хилийн зурвас газарт хил хамгаалалтын зориулалтайгаас бусад дэд бүтэц, барилга байгууламж барих, үйл ажиллагаа явуулах, газар ашиглах

эрх олгохдоо холбогдох төрийн захиргааны байгууллага, Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдал, улсын хил хамгаалалтад сөргөөр нөлөөлөх эсэх талаар улсын хил хамгаалах байгууллагаас дүгнэлт гаргуулна.

5.9.3.Улсын тусгай хамгаалалттай газар нутагтай давхцал бүхий Улсын хилийн зурвас газарт Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу газар ашиглуулах асуудлыг Улсын хил хамгаалах байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

5.9.4.Улсын хилийн зурвас газарт өвөлжөө, хаваржаа, уст цэг, бэлчээр, газар тариалан, төмс хүнсний ногоо, аялал жуулчлал, газар ашиглах асуудлыг улсын хил хамгаалах байгууллага, тухайн аймаг, сумын Засаг дарга нар хамтран шийдвэрлэж, гэрээ байгуулан, хяналт тавьж ажиллана.

Зургаа.Газрыг улсын тусгай хэрэгцээнээс гаргах үйл ажиллагаа

6.1.Аймаг нийслэлийн Засаг дарга эсхүл холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага газрыг улсын тусгай хэрэгцээнээс гаргах хүсэлтээ үндэслэл, тайлбарын хамт газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гаргана.

6.2.Газрыг дараах үндэслэлээр улсын тусгай хэрэгцээнээс хэсэгчлэн эсхүл бүхэлд нь гаргаж болно:

6.2.1.Газрыг улсын тусгай хэрэгцээнд шинээр авахад одоо байгаа улсын тусгай хэрэгцээний газартай давхацсан эсхүл улсын тусгай хэрэгцээний газрын хилийн зааг, талбайн хэмжээнд зайлшгүй өөрчлөлт оруулах шаардлагатай болсон;

6.2.2.Газрын тухай хуулийн 16.1.5-16.1.7-д заасан зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан газар нь байгаль орчин, экологийн нөлөөллөөс хамааран зориулалтын дагуу хэвийн үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон нь холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон;

6.2.3.Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын бүтээгдэхүүн хуваах гэрээг Газрын тосны тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан үндэслэлээр гэрээг цуцалсан;

6.2.4.Газрын тухай хуулийн 16.1.13-д заасан зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан газрын бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжиж дууссан;

6.2.5.Газрыг улсын тусгай хэрэгцээнд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны зорилго биелсэн;

6.2.6.Холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагаас газрыг улсын тусгай хэрэгцээнээс гаргах тухай санал ирүүлсэн.

6.3.Газрыг улсын тусгай хэрэгцээнээс хэсэгчлэн болон бүхэлд нь гаргах саналд дараах бичиг баримтыг хавсаргана:

6.3.1.Газрыг улсын тусгай хэрэгцээнээс гаргах болсон буюу энэ журмын 6.2-т заасан үндэслэл, шаардлагын дагуу тодорхойлсон танилцуулга, холбогдох шийдвэрийн төсөл;

6.3.2.Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дүгнэлт;

6.3.3.Газрыг улсын тусгай хэрэгцээнээс хэсэгчлэн гаргах тохиолдолд тухайн газрын хил заагийн эргэлтийн цэгийн солбицол, талбайн хэмжээ болон тэдгээрийн байршлыг харуулсан зураг;

6.3.4.Энэ журмын 3.14.3-т заасан гэрээг дүгнэсэн акт.

6.4.Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн газрыг улсын тусгай хэрэгцээнээс гаргах үндэслэл бүрдээгүй үзсэн тохиолдолд тодорхой үндэслэл, тайлбарыг дурдан хүсэлтийг албан бичгээр буцаана.

6.5.Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 6.3-т заасан саналыг, шийдвэрийн төсөл, холбогдох бусад материалын хамт Засгийн газрын ажлын албанд хүргүүлнэ.

6.6.Газрын тухай хуулийн 16.1.1-д заасан зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнээс гаргах тохиолдолд газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 6.3-т заасан саналыг холбогдох бусад баримтын хамт Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

6.7.Засгийн газар энэ журмын 6.3-т заасан санал, тогтоолын төслийг хэлэлцэн Газрын тухай хуулийн 18.1.2-д заасны дагуу шийдвэрлэх, эсхүл мөн хуулийн 17.1.3-д заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

6.8.Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага газрыг улсын тусгай хэрэгцээнээс гаргасан тухай эрх бүхий байгууллагын шийдвэрийг холбогдох аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

Долоо.Бусад

7.1.Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 3.14.3-д заасан гэрээний хэрэгжилтийг 2 жил тутамд дүгнэж, хяналт тавьж ажиллана.

7.2.Газрын тухай хуулийн 16.1.3-д заасан зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан газарт хүн амд аюул, эрсдэл учруулж болзошгүй үйл ажиллагаа явуулах тохиолдолд хил залгаа газар нутгийн удирдлага болон айл өрхөд 60 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

7.3.Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага шаардлагатай тохиолдолд Төрийн болон албаны нууцын мэдээлэлд хамаарах улсын тусгай хэрэгцээний газрын талаарх лавлагаа, мэдээллийг зохих журмын дагуу холбогдох байгууллагад өгч болно.

7.4.Энэ журамд заасан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, улсын тусгай хэрэгцээний газрыг ашиглах горим, дэглэмийг зөрчсөн тохиолдолд газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага холбогдох гэрээг цуцлах талаар санал гаргаж болно.

7.5.Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтыг эрхэлж, мэдээллийн санг бүрдүүлэн хөтлөнө.

7.6.Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.